



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ

7
АНГИ

МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 20 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

Ёлын амны ёочин

Аравдугаар сарын энэ өдрүүдэд Ёлын ам тув тунгалаг. Горхи ус, уул сарьдаг, өвс ургамал, мөс зайрмаг, үүл тэнгэр ер бүгд тув тунгалаг. Ёлын амны ус мөсөн зайрынхаа захыг хүлхэн урсана. Тэрхүү мөсөн зайр нь үүлсийн хэвийг бүрдүүлээд, мөнхүү тунгалагт нь өөрийгөө үзэхүй толиноос ялгаагүй тодорхой.

Арцын сайхан үнэр хөндийгөөр нэг тархаад, салхины чиг дагуу цоггүй, утаа үгүйгээр уугина. Угалзан уулын хормойд арцны бутны захад суухад тэрүүхэнд урсах усан хар тугалганы хайлмал адил гогцоорон мушгирч, хөлөрсөн адуу ирж уруул дүрэн залгилж харагдана. Бөв бөөрөнхий, бав бараан хэдэн адуу ус уухдаа туурайн гишгэдлээр нурсан мөсөн зайрын чимээг сонссоноос уу, чихээ хайчлан сортолзоод, уруулаасаа ус дуслуулан, алсын уулсыг оройг ажихыг дагуулан харвал тэртээ оргилын дээр тас юм уу бүргэдийн аль нэг бололтой ихээ том шувуу эргэлдэн эргэлдэнэ. Тэнгэр огтхон ч үүлгүй магнагтаад, тэрхүү цэгийн төдий харагдах хар шувуу уулын дээгүүр давж одов оо.

Усны хөвөөн дэх зүлэг ширэг нов ногооноороо. Ёлын амны усны хөвөөнд улирлын дөрвөн өнгө бүрджээ. Ширэг зүлэг ногоон нь зуных, шил шиг мөс цас нь өвлийнх, орог хул өвс нь намар, хаврынх.

Хөндлөн хөх хөндийн баруунтайгаас хөөмийлөн исгэрэх салхи нь ёочин хөгжмийн эгшигтэй агаад саяын өгүүлэгч бүхнийг улмаа тунгалагшуулан лимбэдэх мэт байх нь санаа сэтгэлд мөн анхилуун сайхныг бий болгоно. Цатгалан адууны нойтон хомоолын үнэр бас нэгэн шинэ арцыг бий болгон сэнгэнээд, ойрхон баруун хөндийд амгайн чимээ шаргихад ус уугаад хөрвөөж тарвайсан адууны зарим мөн тийшээ зөөлхнөөр үүрсэх ажээ. Ийнхүү үүрсэх нь Ёлын амны ёочинч салхинаа дахин нэг хөгийг нэмээд, үл сонсогдох боловч үргэлжлүүлэн аялгуулж, сэтгэлийг тайтгаруулан илбэдэх уянгалгийг бүтээсээр байх болно. Зүүн сайхан уулын зүрхний ховдол нь Ёлын ам юм.

Б.Золбаяр

*Ховдол- зүрхний доод тасалгаа, цусан судлаар явж буй цусыг хөдөлгөөнд оруулдаг зүрхний нэг хэсэг

Монгол хэлний даалгаврууд

1. Аравдугаар сарын Ёлын амны улирлын өнгийг дүрсэлсэн хэсгийг олоорой.
 - A. Аравдугаар сарын энэ өдрүүдэд Ёлын ам тув тунгалаг. Горхи ус, уул сарьдаг, өвс ургамал, мөс зайрмаг, үүл тэнгэр ер бүгд тув тунгалаг.
 - B. Тэрхүү цэгийн төдий харагдах хар шувуу уулын дээгүүр давж одов оо.
 - C. Арцын сайхан үнэр хөндийгөөр нэг тархаад, салхины чиг дагуу цоггүй, утаа үгүйгээр уугина.
 - D. Зүүн сайхан уулын зүрхний ховдол нь Ёлын ам юм.

2. “Ёлын амны ус мөсөн зайрынхаа захыг хүлхэн урсана” гэсэн өгүүлбэр ямар утгыг илтгэж байна вэ?
 - A. усан дээгүүр өрөмтөн хөлдсөн нимгэн мөс царцаж буйг
 - B. усан дээгүүр өрөмтөн хөлдсөн нимгэн мөс хөлдөж буйг
 - C. усан дээгүүр өрөмтөн хөлдсөн нимгэн мөс томорч буйг
 - D. усан дээгүүр өрөмтөн хөлдсөн нимгэн мөс гэсэж буйг



3. “Ёлын ам”-ыг дүрсэлсэн зохиогчийн сонин содон үг хэллэг аль нь вэ?
- A. зүрхний ховдол
 - B. тув тунгалаг
 - C. мөсөн зайр
 - D. зүүн сайхан уул
4. Эхийн гол санаа нь “Үзэсгэлэнт Ёлын ам Зүүн сайхан уулын амин судал юм” бол үүнийг илэрхийлэх өгүүлбэр аль вэ?
- A. Хөндлөн хөх өндийн баруунтайгаас хөөмийлөн исгэрэх салхи нь ёочин хөгжмийн эгшигтэй.
 - B. Аравдугаар сарын энэ өдрүүдэд Ёлын ам тув тунгалаг.
 - C. Зүүн сайхан уулын зүрхний ховдол нь Ёлын ам юм.
 - D. Ёлын амны усны хөвөөнд улирлын дөрвөн өнгө бүрджээ.
5. “Ангийн охидуудын олонхын саналыг авлаа” алдаатай өгүүлбэрийг зөв болгож зассан нь аль вэ?
- A. Ангийн охидын олонхын саналыг авлаа.
 - B. Охидуудын олонхын саналыг авлаа.
 - C. Ангийн охидуудын олонхын саналуудыг авлаа.
 - D. Охидуудын олонхуудын саналыг авлаа.
6. “Ийнхүү үүрсэх нь Ёлын амны ёочинч салхинаа дахин нэг хөгийг нэмээд” өгүүлбэрт байгаа “нэг” гэсэн тооны нэр ямар үүргээр орсон бэ?
- A. хурдыг нэмсэн
 - B. хэмжээг нэмсэн
 - C. хүчийг нэмсэн
 - D. чимээг нэмсэн
7. Эрчимжүүлсэн утгат тэмдэг нэрсийг эхээс зөв олсон нь аль вэ?
- A. тув тунгалаг, бөв бөөрөнхий, зөөлхнөөр
 - B. тув тунгалаг, бөв бөөрөнхий, нов ногоон
 - C. тув тунгалаг, бөв бөөрөнхий, уянгалаг
 - D. бөв бөөрөнхий, цэгийн төдий, нов ногоон
8. “Цатгалан адууны нойтон хомоолын үнэр бас нэгэн шинэ арцыг бий болгон сэнгэнээд, ойрхон баруун хөндийд амгайн чимээ шаргихад ус уугаад хөрвөөж тарвайсан адууны зарим мөн тийшээ зөөлхнөөр үүрсэх ажээ.” өгүүлбэрээс дуурайх үгсийг зөв олоорой.
- A. уугаад, шаргихад, үүрсэх
 - B. сэнгэнээд, шаргихад, тарвайсан
 - C. болгон, сэнгэнээд, шаргихад
 - D. хөрвөөж, тарвайсан, уугаад
9. “Ихээ том шувуу эргэлдэн эргэлдэнэ”, “Тэнгэр огтхон ч үүлгүй магнагтана” гэсэн энгийн өгүүлбэрүүдийг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр болгосон нь аль вэ?
- A. Ихээ том шувуу эргэлдэн ниссэн учраас тэнгэр огтхон ч үүлгүй магнагтана.
 - B. Ихээ том шувуу эргэлдэн нисэнгүүт тэнгэр огтхон ч үүлгүй магнагтана.
 - C. Ихээ том шувуу эргэлдэн нисмэгц тэнгэр огтхон ч үүлгүй магнагтана.
 - D. Ихээ том шувуу эргэлдэн нисэж, тэнгэр огтхон ч үүлгүй магнагтана.






10. “Усны хөвөөн дэх зүлэг ширэг нов ногооноороо. Ёлын амны усны хөвөөнд улирлын дөрвөн өнгө бүрджээ” хэсгээс зэрэгцсэн нийлмэл үгийг олоорой.
- A. ширэг зүлэг
 - B. усны хөвөөн дэх
 - C. өнгө бүрджээ
 - D. дөрвөн улирал

Үндэсний бичгийн даалгаврууд


11. “ᠨᠢᠴᠢᠨ” гадаад үгийг уншаарай.

- A. Комикс
- B. Коллеж
- C. Хумс
- D. Комисс

12. “хони мал хобур эрдэни” гэсэн галигийг зөв бичсэн хэсэг аль вэ?

A.	B.	C.	D.
			





13. “ЭГЭ” гэсэн бүтэцтэй урт эгшиг орсон үгийг олоорой.

A.	B.	C.	D.
			

14. Хоёулаа хос эгшгээс бүтсэн үгтэй хэсгийг олоорой.

A.	B.	C.	D.
			

15. “ᠨᠢᠴᠢᠨ + ᠨᠢᠴᠢᠨ” холбон зөв бичсэн нь аль вэ?

A.	B.	C.	D.
			



Уран зохиолын даалгаврууд

16. “Хорь түмэд, Хоридай мэргэн”-ий домгийн “...Чи явсандаа яв. Арван нэгэн хөвүүндээ нэр хайрлаач гэж гуйхын ихээр гуйв гэнэ. Тэгэхэд “Хүгдүүд, Галзууд, Хуацай, Халвин, Шарайд, Бодонгууд, Худай, Харгана, Батнай, Гучид, Цагаангууд” гэж арван нэгэн нэр өгсөн юм гэнэ” гэсэн хэсэгт ямар хам сэдэв илэрч байна вэ?
- A. Угсаатны түүхийн
 - B. Дэлхийн түүхийн
 - C. Монгол ахуй соёлын
 - D. Эдийн соёлын
17. Ц.Дамдинсүрэн “Зугаацахаар мордсон нь” найраглалд “Арслан барс хоёр ноцолдож байгаа ч юм шиг Ачаатай цагаан тэмээ хэвтэж байгаа ч юм шиг” гэж дүрсэлсэн нь уран дүрслэлийн ямар арга болох вэ?
- A. Хэтрүүлэл
 - B. Амьдчилал
 - C. Хүншүүлэл
 - D. Адилтгал
18. Д.Нацагдорж “Хуучин хүү” өгүүллэгийн “Өвлийн хүйтнийг адуу манаж өнгөрүүлэн, зуны халууныг хонь хариулж гэтэлгэх бөгөөд намар ичиж, хавар гарагч тарваганаас зовлонтойгоор он жил нөгчүүлнэ” гэсэн дүрслэлээс амьдралын ямар хэв маяг харагдаж байна вэ?
- A. хүнд байдалд орсон
 - B. шинэ зүйл рүү хүсэн тэмүүлсэн
 - C. гуньхралтай хөөрхийлөлтэй
 - D. урагшгүй бүтэлгүй
19. Б.Ринчен “Шүхэрч Буनिया” өгүүллэгийн “... анх лойлинд орхимжоо дэлгэн нисэж явсан лам нарын бяцхан баримлыг үзсэнээсээ санаа авч хулгайгаар ламын хэрэглэл, номын баринтгийн хуучин даавуу сэм зүүж багшийнхаа хуучин шүхрийн үлгэрээр хийгээд хашаан дээрээсээ үүрийн шөнөөр үсэрч шүхрийнхээ голд нь салхи дээшээ гарах нүхтэй болгож тэр хэмжээг нь их болгосоор давхар илүү байшингийн дээрээс зүрхлэн үсэрч сургуулийг нь хийж шүхрээ хүн унтсан хойно хулгайгаар засаж, сэлбэсээр ...” хэсэгт Буनिया хүүгийн ямар зан чанар илэрч байна вэ?
- A. хөнгөн хийсвэр
 - B. сониуч шохоорхуу
 - C. дүрсгүй зүггүй
 - D. гэнэн томоогүй
20. Олон тооны дагавраар сүүл холбон, шүлгийн айзам хэмнэлийг тааруулан бичсэн мөртлийг зөв олоорой.
- A. Хэнтий, Хангай, Саяны өндөр сайхан нуруунууд
Хойд зүгийн чимэг болсон ой хөвч уулнууд
 - B. Эрчүүлийнх нь андгай тангараг шагайндаа
Эцэг эхийнх нь эртний буян шагайндаа
 - C. Цаашлан цаашлан хүүшилдэг цанхилзуур намар нь уртын дуутай
Цан шамарга цацагладаг цатгалдуу өвөл нь “Жангар”-ын туультай
 - D. Арслан мэт ноёдыг
Барс мэт түшмэд дагах

